



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/206

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсэг, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5, дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны хүсэлт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1 дэх хэсэг, 2.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дахь заалтын хүрээнд аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн хавсралтад дурдагдсан алба хаагчдыг "Өөртөө хайртай 72 цаг" нөхөн сэргээх эмчилгээнд хамруулахаар тогтсугай.

2. Нөхөн сэргээх эмчилгээнд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ч.Хандмаа)-д, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын *2024* оны
03-дугаар сарын *20*-ны өдрийн *200* дүгээр
захирамжийн хавсралт



**"ӨӨРТӨӨ ХАЙРТАЙ 72 ЦАГ" НӨХӨН СЭРГЭЭХ
ЭМЧИЛГЭЭНД ХАМРАГДАХ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН
НЭРСИЙН ЖАГСААЛТ**

№	Овог нэр	Албан тушаал	Шаардагдах зардал
1	А.Амартүвшин	Цагдаа зохицуулагч ахлах ахлагч	400,000
2	Ц.Батчулуун	Цагдаа зохицуулагч ахлах ахлагч	400,000
3	П.Тулгабаатар	Цагдаа зохицуулагч ахлагч	400,000
4	Т.Бямбасанж	Цагдаа зохицуулагч ахлагч	400,000
5	Ч.Дашдэлэг	Цагдаа зохицуулагч дэд ахлагч	400,000
6		Нийт	2,000,000

__оОо__